

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДАВ

2011 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөл хуралдлаа. Хуралд Монголбанкны Ерөнхийлөгч Л. Пүрэвдорж, Сангийн сайд С. Баярцогт, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун, Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Б.Жавхлан, Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Н.Золжаргал, Сангийн Дэд сайд Ч.Ганхуяг, Сангийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Батбаяр нар оролцов.

Уг хуралдаанаар эдийн засгийн өндөр өсөлтийн үед мөнгөний болон сангийн бодлогын уялдааг хангах, дэд бүтцийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх оновчтой хувилбарыг тогтоох зорилгоор байгуулдагдсан ажлын хэсгийн ажлын явц, 2011 онд хийх ажлын төлөвлөгөөг баталлаа. Төлөвлөгөөнд дунд хугацааны макро эдийн засгийн бодлогыг тодорхойлж, түүний уялдаа холбоог сайжруулах, тулгарч буй бодлогын шийдлүүд болон болзошгүй эрсдлүүдийг олон талаас нь судлах, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлох, улмаар урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн цогц бодлогыг тодорхойлох юм.

Хямралын үед дотоодын арилжааны банкуудад Засгийн газраас гаргасан хадгаламжийн даатгалыг олон улсын стандартын дагуу хадгаламжын даатгалын системд үе шаттайгаар шилжүүлэх, хадгаламжийн даатгалын байгууллагын эрх зүйн орчныг тодорхойлох зорилготой “Хадгаламжын даатгалын тухай” хуулийн үзэл баримтлалын тухай хэлэлцэн ажлын хэсэгт холбогдох үүргүүдийг өглөө.

Арилжааны банкууд дээрх чөлөөт эх үүсвэр, хөрөнгийг ойрын хугацаанд төлөвлөөд байгаа хөрөнгө оруулалтад ашиглах, эдийн засаг руу үр ашигтай байдлаар оруулах хамгийн үр ашигтай хувилбар болох Засгийн газрын дунд болон урт хугацааны үнэт цаас гаргах боломжуудыг ярилцан, цаашид хийх ажлаа харилцан тохиролцов.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд Зээлийн хүүг бууруулах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөрийг хамтран боловсруулах, хэрэгжүүлэх үүргийг Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд өгсөн. Уг үүргийн хэрэгжүүлэхийн тулд хийх шаардлагатай байгаа ажлуудын талаар хэлэлцэн, Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Б.Жавхланаар ахлуулан холбогдох байгуулагуудын удирдах ажилтнуудаас бүрдсэн ажлын хэсэг байгууллаа. Ажлын хэсэг уг хөтөлбөрийн дагуу хийх ажлууд, хариуцах байгууллага, хугацааны талаар дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хариуцуулан зохион байгуулж ажиллахаар шийдлээ.